



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/180

Бөхт

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоол, Үнэлгээний хорооны 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Ерөнхий боловсролын сургуулийн гадна хашаа хийх ажил”-ыг гүйцэтгүүлэхээр “Мандал хаалга” ХХК-тай 38,094,200 (гучин найман сая ерэн дөрвөн мянга хоёр зуун) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. “Ерөнхий боловсролын сургуулийн гадна хашаа хийх ажил”-ыг ажлын даалгаврын дагуу чанартайгаар гүйцэтгэхийг “Мандал хаалга” ХХК-ны захирал (Ц.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

3. “Мандал хаалга” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Мөнхбадрах)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ